



УЛААНБААТАР ХОТЫН  
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР  
ОНӨААТҮГ

Токиогийн 5 дугаар гудамж, 3 дугаар хороо,  
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976) 7015 7015  
Цахим шуудан: usug1959@gmail.com  
Цахим хуудас: www.usug.ub.gov.mn

2024.04.23 № 6/802

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулга

“А” ХХК нь манай байгууллагаас зарласан “Цайны газар, оффисын цахилгаан бараа нийлүүлэх” нэртэй, УСУГ/20240102019 дугаартай тендерийн Багц№1: Гал тогооны цахилгаан бараа нийлүүлэх тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбоотойгоор тодруулга авах тухай хүсэлт цахим системээр ирүүлсэн байна. Үүнд:

ТШЗ-ын 31.1-д зааснаар "Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: "Давуу эрх тооцохгүй" гэж заасан байна.

Манай компани хүнс, хоол үйлдвэрлэл үйлчилгээний үйлдвэр, худалдаа, засвар үйлчилгээний чиглэлээр салбартаа 34 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж буй Үндэсний үйлдвэрлэгч, баялаг бүтээгч компани юм.

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/255 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан заавар мөн Тендерийн тухай хуулийн 8.1-д заасны дагуу дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрээс худалдан авах гэж заасан байгаа тул дараах бараанд

- Цахилгаан плитка
- Буузны жигнүүр
- 1-р хоолны тогоо
- 2-р хоолны тогоо
- Төмс шарагч
- Хоол халуун байлгагч

тус тус "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ын дагуу дотоодын давуу эрх тооцно гэсэн заалтыг ТШЗ-д засаж өгнө үү.

Тодруулга:

ТШЗ 31.1 Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг:  
"Давуу эрх тооцохгүй" гэж заасныг холбогдох нотлох баримт бичгийг үндэслэн  
"Давуу эрх тооцно" гэж өөрчилсөн болно.